



Монгол Улсын
Засгийн Газар

НУБ-ЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН
“ЯДУУРЛЫН СУДАЛГАА, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ
ДЭМЖИХ БОДЛОГЫГ ХӨГЖҮҮЛЭХ” ТӨСӨЛ



ХҮН АМЫН ТООЛЛОГЫН ТОО МЭДЭЭЛЭЛД СУУРИЛСАН ЯДУУРЛЫН ЗУРАГЛАЛ:

Бүс, аймаг, сумын
түвшний үр дүн

**Харолд Коуломб
Томас Оттер**

**Үндэсний Статистикийн Хороо (УСХ)
НУБ-ЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР (НУБХХ)**

2009 оны Гуравдугаар сар

**ХҮН АМЫН ТООЛЛОГЫН ТОО
МЭДЭЭЛЭЛД СУУРИЛСАН
ЯДУУРЛЫН ЗУРАГЛАЛ:**

Бүс, аймаг, сумын түвшний үр дүн

*Харолд Коуломб
Томас Оттер*

Үндэсний Статистикийн Хороо (YCX)
НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр (НҮБХХ)

2009 оны Гуравдугаар сар

ХҮН АМЫН ТООЛЛОГЫН ТОО МЭДЭЭЛЭЛД СУУРИЛСАН ЯДУУРЛЫН ЗУРАГЛАЛ: Бүс, аймаг, сумын түвшний үр дүн¹

ТОВЧ АГУУЛГА

Энэ тайланд Монгол Улсын Хүн ам, орон сууцны 2000 оны тооллого, 2002/2003 оны Амьжиргааны түвшний судалгааны тоо мэдээллийг ашиглан хийсэн ядуурлын зураглалын гол үр дүнг үзүүлэх болно.

Энэ ажилд хүн ам, орон сууцны тооллогын хүрээгээр авч болох амьжиргааны түвшний түүвэр судалгааны хамгийн боломжит дэлгэрэнгүй мэдээллийг ашиглах аргыг хэрэглэсэн. Ингэснээр ядуурлын үзүүлэлтүүдийг тухайн улсын засаг захиргааны буюу суурьшлын хамгийн доод боломжит түвшинд тооцож болох бөгөөд Монгол Улсын тухайд аймаг, сумын түвшинд тооцлоо. Монгол Улсын хувьд аймаг, сумын түвшин дэх ядуурлын байдал ихээхэн ялгаатай учир ийм ядуурлын зураглал нь ядуурлыг бууруулахад чиглэсэн төсөл, хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэхэд статистикийн чухал хэрэгсэл болж өгнө. Аймаг, сумын түвшний үр дүнгийн тооцоог бид мөн өрхийн тэргүүлэгчийн хүйсээр ангилан хийсэн.

НҮБ-ЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН “ЯДУУРЛЫН СУДАЛГАА, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ БОДЛОГЫГ ХӨГЖҮҮЛЭХ” ТӨСӨЛ

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, 3-р давхар, Өрөө 301, Засгийн газрын
2 дугаар байр, Нэгдсэн Үндэстний гудамж-44, Улаанбаатар-46, Монгол улс.
Утас/Факс (976) 11 318637; Утас: (976) 11 319177

¹ Энэхүү ажлыг НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн санхүүжилтээр хийлээ. Энэ нь олон улсын зөвлөх Харолд Коуломб, Томас Оттер болон Үндэсний Статистикийн Хорооны ажилтнуудын бүрэн дэмжлэг, нягт хамтын ажиллагааны үр дүнд бий болсон. Тухайлбал, ноён П. Бямбацэрэн (Дарга), Ч.Дагвадорж (Брөнхий менежер), Хатагтай Д. Оюунчимэг (Хүн ам, нийгмийн статистикийн газрын дарга), Хатагтай Б. Цэрэнханд (Мэдээлэл боловсруулалт, технологийн газрын дарга), Хатагтай Ц. Амартувшин (ахлах мэргэжилтэн), ноён Д. Даваажаргал (мэргэжилтэн). GIS-ийн асуудлыг ноён Л. Мягмарсүрэн цаг тухайд нь шийдвэрлэж өгч байсан. Түүнчлэн НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн зүгээс энэ төслийг хэрэгжүүлэхэд хатагтай Ж. Должинсүрэн, П. Цэцгээ нар хичээл зүтгэл гаргасан. Зохиогчидтой hcoulombe@videotron.ca. холбогдох болно.

УДИРТГАЛ

1. Энэхүү тайланд Монгол Улсын Хүн ам, орон сууцны 2000 оны тооллого, 2002/2003 оны Амьжиргааны түвшний судалгааны тоо мэдээллийг ашиглан хийсэн ядуурлын зураглалын тооцоо, үр дүнг үзүүлэх болно. Элбэр болон түүний хамтрагчдын боловсруулсан аргачлалыг (2002, 2003) ашиглан бид ядуурлын үзүүлэлтүүдийг засаг захиргааны боломжит хамгийн доод түвшинд тооцоходоо хүн, ам орон сууцны тооллогын хүрээгээр авч болох амьжиргааны түвшний судалгааны хамгийн дэлгэрэнгүй нарийвчилсан боломжит мэдээллүүдийг ашиглах аргыг ашигласан. Үр дүнг бүс, аймаг, сумын түвшингээр гаргалаа.

2. Сүүлийн арван жилд ядуурлын түвшинг² ядуурлын дүр төрхийг тодорхойлох, үнэлэх, хянах олон арга хэрэгсэлүүдээр тодорхойлж байжээ. Өрхийн судалгаагаар цуглуулсан өрхийн орлого, зарлагын талаарх нарийвчилсан тоо мэдээллийг үндэслэн хүн амын амьжиргааны түвшний шинж байдлыг мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр тодорхойлж ирсэн нь ядуурлыг бууруулахад чиглэсэн зарим бодлого хөтөлбөрийг үнэлэхэд дэм болж, ядуурлын түвшинг бүс нутгуудын, бүлгүүдийн түвшинд гаргаж, зэрэгцүүлэлт харьцуулалт хийхэд ашиглагдаж байжээ. Тэдгээр өрхөд суурилсан судалгааны ажлуудын үр дүн нь хүн амын аж байдлыг өрхийн түвшинд өрөнхийд нь харуулах, түүнчлэн ядуу хэсгийн талаар зарим мэдээллийг олж мэдэхэд тустай ч зарим сул тал бий.

Ялангуяа, ядуурлыг бууруулахад чиглэсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шийдвэр гаргагчид, төлөвлөгчдөд нилээд нарийвчилсан мэдээлэл шаардлагатай байдаг. Тэдэнд хүн амын суурьшлаарх мэдээлэл, тухайлбал, хөрш зэргэлдээ газрууд, аймаг, хот, суурин, тосгоны түвшинд тооцсон мэдээлэл тун чухал. Ядуурал ихтэй, тусlamж дэм хэрэгтэй хэсэг хөдөөд л илүү их байна гээд өрөнхийлөн хэлээд байх нь хэнд ч мэдээжийн бөгөөд хэтэрхий бүдэг мэдээлэл болно. Иймд Монгол Улсын бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчидад чухамдаа ямар аймаг, ямар суманд ядуу өрхүүд түлхүү байгааг тодорхой мэдээлэх нь илүү үр дүнтэй, илүү бодитой ажил болох нь дамжиггүй.

Сумын түвшний мэдээлэлгүй зөвхөн бүс, аймгийн түвшний мэдээллийг ашигласнаар ядуурлын бодит байдлыг бүрхэгдүүлж, харьцангуй ядуу бус өрхүүд ядуурлын зорилтот хөтөлбөрүүдэд хамрагдах нөхцөлийг бий болгоно. Засаг захиргааны аль болох доод түвшний нарийвчилсан мэдээлэлтэй болсноор үр ашиггүй урсаж байгаа зардлыг хязгаарлаж илүү үр ашигтай, ядуурлын эсрэг үр нөлөөтэй хөтөлбөрийг бий болгох нөхцөлийг бүрдүүлнэ. Бүс нутгийн хүрээнд газар нутгийн суурьшил, тархалтаар ядуурлын үзүүлэлтүүдийг тооцон гаргах нь ядуурлын түвшин, тэгш бус байдлыг суурьшлаар илэрхийлэх чухал ач холбогдолтой мэдээлэл болно.

3. Энэхүү ажлыг хийхэд Элбэр, Ланжоу болон Ланжоу (2002, 2003) нарын боловсруулсан аргачлалыг ашигласан бөгөөд ингэснээр өрхийн зарлагын

талаарх мэдээллийг ашиглах, тооцооны үр дүн нь ядуурлын түвшингийн нэгдсэн тооцоотой бүрэн тохирч байх, ядуурлын бүх үзүүлэлтүүдийн стандарт алдааг тооцох шаардлагатай болдогоороо бусад аргуудаас³ илүү нарийн төвөгтэй мэт санагдаж болох юм. Ийм аргаар хийсэн ядуурлын зураглалын мэдээлэл нь нэгдсэн байдлаар гаргасан ядуурлын түвшний тооцоотой яв цав таарч байх ёстой бөгөөд энэ нь ердөө л ядуурлын түвшний мэдээллийг илүү нарийвчлан задалж засаг захиргааны нэгж суурьшлын түвшнээр гаргаж ядуурлын түвшний талаарх мэдээллийн үр дүнг илүү тодорхой, бодитой болгож өгч байгаа юм. Энэхүү тайланд Монгол Улсын ядуурлын зураглалын тооцооллыг баримтжуулж тусгалаа. Харин нэг гол анхаарах зүйл бол энэхүү зураглалыг цаашид хэрхэн яаж ашиглах талаар дорвитой алхам хийхгүй тохиолдолд бүрэн төгс ажил болж чадахгүй юм.

4. Тайлангийн бусад хэсэгт бид ашигласан аргачлалаа хэнд ч болов ойлгомжтой байлгах зорилгоор аль болох энгийн үгээр тайлбарлаж, улмаар ашигласан мэдээллийнхээ талаар нэмэлт тайлбаруудыг хийлээ. Эцэст нь тооцооныхоо үр дүнг хүйсээр ангилан хийсэн тооцооны хамт тусган үзүүлсэн. Аргачлалын талаарх онолын нарийвчилсан тайлбарыг нэгдүгээр хавсралтаас, үр дүнгийн нарийвчилсан тооцоог хоёроос дөрөвдүгээр хавсралтаас тус тус үзэх боломжтой.

АРГАЧЛАЛ⁴

5. Энд ашигласан аргачлалын гол үзэл санаа нь чухамдаа маш тодорхой. Эхлээд амьжиргааны түвшний судалгаа болон хүн ам, орон сууцны хамгийн сүүлийн тооллогын ижил төрлийн үзүүлэлтүүдийн багцыг тодорхойлж түүнийхээ хүрээнд Амьжиргааны түвшний судалгааны мэдээллийг ашиглан нэг хүнд ногдох зардлын регрессийн загвар гаргана. Дараа нь энэ загвараараа тооцсон коэффициентуудаараа хүн ам, орон сууцны тооллогын мэдээллийг ашиглан тооллогод хамрагдсан өрх нэг бүрийн зарлагын түвшинг тодорхойлно. Эцэст нь ингэж тооцсон өрхийн зарлагын мэдээллээ ашиглан хүн амын амьжиргааны түвшинг илэрхийлэх үзүүлэлтүүдийг (ядуурлын хамралтын хүрээ, гүнзгийрэлт, мэдрэмж, тэгш бус байдал) оршин суугаа газар нутгаар нь ангилан тооцно.

6. Хэдийгээр энэхүү аргачлал нь ойлголтын хувьд хялбар мэт боловч тооцооны хувьд төвөгтэй маш нарийн ажилбаруудтай. Ийм төвөгтэй байдал нь голчлон хүн амын тооллогод хамрагдсан өрх бүрийн зарлагын түвшинг таамаглан тодорхойлох регрессийн загвар байгуулах үед орон зайн автокорреляц (нэг газар нутагт оршин байгаа өрхүүдийн хэрэглээ өөр хоорондоо харилцан хамааралтай) болон хетероскедастисити (хэрэглэж байгаа тооцооны загварын тооцооллын дотоод уялдаа) байж болохыг бодолцох зэргээс шалтгаалж байдаг. Эконометрикийн эдгээр нөхцөлийг маш хянамгай баримталснаар регрессийн шинжилгээн дэх үнэлэлтүүдийг

³ Зураглал хийх бусад аргачлалыг Хеннингэр (1998)-ээс үзэж болно.

⁴ Энэ нь хөгжих байгаа Азийн болоод бусад олон оронд хэрэглэгдэж байгаа аргачлал юм. Тухайлбал. Коуломб, Водон нарын (2007) Баруун болон Төв Африкийн орнуудын Ядуурлын зураглалыг гаргах санаачлагад одоогоор 15 орон оролцсон.

хазайлтгүй, тооцоо зөв байх нөхцөлийг бүрдүүлнэ. Тооцоог хийж байхдаа ялимгүй ч болтугай алдаа гаргахгүй байх үүднээс хүн амын аж байдлыг илэрхийлэх үзүүлэлт бүрийн стандарт алдааг тооцох шаардлага гардаг. Эдгээр стандарт алдааны хэмжээ бидэнд ядуурлын үзүүлэлтүүдийг суурьшлын хамгийн доод ямар түвшинд тооцож болохыг зааж өгнө. Тооцоо засаг захиргааны буюу суурьшлын доод түвшин рүү ойртох тусам эконометрикийн загварт хамрагдаж байгаа өрхийн тоо цөөрч, үр дүн бүдгэрч, тооцооны оновчтой байдал суларна. Иймд бид ядуурлын үзүүлэлтүүдийн түвшинг илүү найдвартай байх суурьшлын түвшинд тогтоож авна. Иймд дээр дурьдсан стандарт алдааны түвшин нарийвчилсан тооцоогоо бид хаана, суурьшлын аль түвшинд зогсоохыг тодорхойлж өгнө. Энэ аргачлалын талаар дэлгэрэнгүй мэдээллийг нэгдүгээр хавсралтаас үзнэ үү.

ТОО МЭДЭЭЛЭЛ

7. Ийм маягийн ядуурлын зураглалыг гаргахад мэдээлэл тун чухал суурь нөхцөл болдог. Хамгийн чухал нь зарлагын загвар ашигласан өрхийн судалгааны тоо мэдээлэл, хүн ам, орон сууцны тооллогын тоо мэдээлэлтэй байх шаардлагатай. Урьд нь ийм судалгаанууд хийгдээгүй бол судалгааг үндэслэн мөнгөн орлогод тулгуурласан ядуурлын түвшинг тодорхойлох шаардлагатай. Ийм тооцоог үндэслэсэн өрхийн түвшний аж байдлын индекс, ядуурлын шугамын мэдээллийг ядуурлын зураглалыг гаргахад ашиглана. Өрхийн түвшний мэдээллээс гадна мөнгөн дүнгээр тодорхойлогдсон эсэхээс үл хамааран хүн амын бүлэглэлүүд, ерөнхий шинж байдлыг илэрхийлсэн мэдээлэл тухайлбал, газар зүйн ялгаатай байдал, түүх, яс үндэс, зах зээлийн боломж, нийтийн үйлчилгээ, дэд бүтэц, улс төрийн бодлогоос хамаарах бусад асуудлууд зэрэг нь хүн амын амьжиргааны түвшний ялгааг тодорхойлох ядуурлын зураглалыг гаргахад чухал хэрэгтэй байдаг. Монгол улсын хувьд зарим ийм мэдээлүүд олдоцтой байсан.

Тооллого:

8. Монгол Улс хамгийн сүүлд 2000 оны Нэгдүгээр сард Хүн ам, орон сууцны тооллогоо хийсэн. Энэ тооллогын асуулгад нарийвчилсан олон асуултууд орсон хэдий ч өрхийн орлого, зарлагын талаар огт мэдээлэл байхгүй байна. Зөвхөн хувь хүний түвшинд хүн ам зүй, боловсрол, эдийн засгийн үйл ажиллагааны талаар асуултууд оржээ. Өрхийн түвшинд ердөө орон сууцны талаарх асуулт л орсон байна. Тооллогын мэдээллийн санг үзвэл 2.2 сая хүн, ойролцоогоор 541,000 өрх хамрагдсан байна. Тооллогын ажлыг дунджаар 50 өрхийг хамарсан тооллогын 11,000 нэгжид явуулсан байна.

Амьжиргааны түвшний судалгаа:

9. Амьжиргааны түвшний судалгаа нь өрхийн түвшний зарлагын мэдээллийг цуглуулсан үндэсний хэмжээний судалгаа юм. Энэ судалгаа нь 2002/2003 онд хийгдсэн учир цаг хугацааны хувьд ядуурлын зураглалд ашиглахад хамгийн тохиромжтой нь байлаа. Энэ судалгаагаар цуглуулсан мэдээлэл нь тооллогын асуултынхтай төстэй байсан.

10. Бидний регрессийн загварт ашигласан аж байдлын индекс нь (нэг хүнд ногдох зарлага) Амьжиргааны түвшний судалгааны мэдээлэлд үндэслэн тооцсон ядуурлын түвшингийн мэдээлэлтэй (YCX, 2004) ижил байсан. Ийнхүү өрхийн түвшний аж байдлын индекс, ядуурлын шугамыг ашиглаж өмнө тооцсон ядуурлын түвшин, шинээр гаргасан ядуурлын зураглал зэргийн тооцоо хоорондоо тохирих учиртай юм. Ингэснээр шинээр тооцсон ядуурлын үзүүлэлтүүд өмнө нь ядуурлын үзүүлэлтийг тооцсон суурьшлын түвшин бүрт буюу Амьжиргааны түвшний судалгааны мэдээллийг ашиглан ядуурлын үзүүлэлтүүдийг тооцож болох суурьшлын хамгийн доод түвшинд тохирич байгаа эсэхийг ч шалгах боломжтой.

Засаг захиргааны нэгж

11. Монгол Улсын засаг захиргааны нэгжийн бүтэц чухамдаа маш тодорхой бөгөөд ойлгомжтой. Дээд түвшин нь 21 аймаг, нийслэл хоттой, эдгээр нь таван бүст хуваагддаг бөгөөд доод түвшнийг нь 331 сум, нийслэл хотын есөн дүүрэг бүрдүүлж байна. Нэгдүгээр хүснэгтэд эдгээр засаг захиргааны нэгжүүдийн талаарх зарим мэдээллийг үзүүлэв. Аймгууд хоорондоо хүн амынхаа тоогоороо их ялгаатай, тухайлбал, Говьсүмбэр аймагт 12449 хүн амьдарч байхад нийслэл хотод 2000 онд ойролцоогоор 773000 хүн амьдарч байжээ. Эдгээр 21 аймаг, нийслэл хотыг нийт 340 сум/дүүрэгт хуваасан бөгөөд эдгээр сум/дүүргийн хүн амын тоо өөр хоорондоо их зөрүүтэй, тухайлбал, хөдөөгийн Чойр сумын хүн амын тоог (873 хүн), нийслэл хотын Сонгинохайрхан дүүргийнхтэй харьцуулахад ихээхэн зөрүүтэй юм.

Хүснэгт 1: Монгол Улсын Засаг захиргааны нэгжийн талаарх тоо мэдээлэл

Засаг захиргааны нэгж	Нэгжийн тоо	Өрхийн тоо			Хүн амын тоо		
		Голч	Доод	Дээд	Голч	Доод	Дээд
Бүс	5	104,914	47,464	159,991	445,613	205,395	772,969
Аймаг (тэмдэглэлийг үз)	22	18,708	2,953	159,991	85,328	12,449	772,969
Сум (тэмдэглэлийг үз)	340	770	207	31,962	3,270	873	159,346

Тэмдэглэл: Тоо мэдээлэлд дүн шинжилгээ хийх зорилгоор Улаанбаатар хотын 9 дүүргийг сум, нийслэл хотыг аймаг хэмээн төсөөлж тооцоонд ашигласан. Засаг захиргааны нэгжийн түвшнийг нь хувьд авч үзвэл Улаанбаатар хотыг аймгуудын түвшинд, сум, дүүргүүдийг аймгийн дараах түвшинд авч үзсэн.

Эх сурвалж: 2000 оны Хүн ам, орон сууцны тооллогын мэдээллийг үндэслэн хийсэн зохиогчийн тооцоо

ҮР ДҮН

12. Ядуурлын үзүүлэлтүүдийн тооцооны найдвартай байдлыг хамгийн дээд түвшинд байлгах үүднээс амьжиргааны түвшний судалгааны тоо мэдээллийн төлөөлөх чадвар сайн байх засаг захиргааны буюу суурьшлын хамгийн доод түвшинд бид загварчлалаа ашигласан. Түүвэрлэлтийн загвартаа Улаанбаатар, Аймагийн төв, байсан.

Сумын төв, Хөдөө гэсэн суурьшлын дөрвөн шатлалтай байхаар тусгасан. Өрхийн түвшингийн зарлагын загварыг Амьжиргааны түвшний судалгаа, Хүн ам, орон сууцны тооллогын аль алинд нь байгаа ижил үзүүлэлтүүдийг ашиглан суурьшлын шатлал бүрээр хийсэн.

Үе шат 1: Тоо мэдээллийн зэрэгцүүлэлт

13. Эхний ажил бол амьжиргааны түвшний судалгаа, хүн ам, орон сууцны тооллогын ижил үзүүлэлтүүд чухамдаа яг ижил агуулгыг илэрхийлж байгаа эсэхийг батлах зорилт тавьж ажилласан. Үүний тулд хоёр судалгаанд ашигласан асуултуудын ижил асуултуудыг томъёолсон болон асуусан байдлыг зэрэгцүүлэн шалгасан. Дараа нь эдгээр хувьсагч үзүүлэлтүүдийн дунджуудыг харьцуулж 95 хувийн итгэмжлэгдсэн интервалын (confidence interval) түвшинд тэнцүү байна уу гэдгийг авч үзсэн. Ингээд тооллогын мэдээллийг ашиглан тооцсон аж байдлын түвшинг илэрхийлэх үзүүлэлтүүд нь амьжиргааны түвшний судалгааг ашиглан тооцсон үзүүлэлтүүдтэй тохиорхгүй байгаа тохиолдолд уг үзүүлэлтийг тооцоноосоо хасах зарчмыг баримтлалаа болгосон.⁵ Энэхүү статистикийн зэрэгцүүлэх үйлдлүүдийг засаг захиргааны буюу суурьшлын шатлал (strata) бүрт хийгдсэнийг дээр тэмдэглэсэн билээ. Улмаар стандарт алдааг тооцоходо хоёр үе шаттай түүврийн загвар ашигласан. Үр дүнг Хоёрдугаар хавсралтад үзүүлэв.

Үе шат 2: Судалгааны мэдээлэлд суурилсан регрессийн тооцоо

14. Гуравдугаар хавсралтад Амьжиргааны түвшний судалгааны мэдээлэлд үндэслэн суурьшлын шатлалаар (strata) тооцсон регрессийн шинжилгээнүүдийн үр дүнг (Ordinary Least Squares-Хамгийн бага квадратын аргаар тооцсон) үзүүлэв. Үл хамарагч хувьсагчуудыг сонгохдоо хувьсагчуудыг өөр хооронд нь дахин давтан буцааж сэлгэж шалгах аргыг хэрэглэсэн. Үр дүнг шалгаж үзэхэд бүх коэффициентүүдийн өмнөх тэмдэг төсөөлж байсан үр дүнг үзүүлсэн. Гэхдээ эдгээр загварыг шинжин хэлэлцэхэд асуудлын гол оршоогүй болохыг давтан тэмдэглэж байна. Эдгээр нь гагцхүү урьдчилан хийсэн төсөөллөө шалгахад ашиглаж буй загвар болохоос биш учир шалтгааны хамаарлыг шинжлэхэд ашиглагдах ядуурлын загварыг тодорхойлогч биш юм. Ядуурлын зураглалд ашигласан загварууддаа бид зөвхөн регрессийн урьдчилан тодорхойлогч хүчийг гол болгон анхаарснаас бус бусад зүйлийг тухайлбал эндоген хувьсагчдыг (endogenous-dotroosoo хувиран үүсэх гэх) анхааран авч үзээгүй билээ.

Энэ шатанд зарим хувьсагчуудын бүлэглэлийн дундажийг нэгтгэх замаар байршилын нөлөөг хянах оролдлого хийсэн. Мөн түүнчлэн суурь загварынхаа үлдэгдэл хүчин зүйлүүдийг (residuals) хамааран хувьсагч болгон авч хэд хэдэн багц регрессийн тооцоо хийсэн. Эдгээрийн үр дүнг энд үзүүлэхгүй бөгөөд харин эдгээр тооцоог

⁵ Эконометрикийн загвартая хувьсагчуудын шугаман давхцлын (multicollinearity) доголдол гаргахгүй үүднээс тооцооллоос 0.03-с бага, 0.97-с дээш утгатай хуваагдагч (dichotomic) хувьсагчуудыг хасах, эсвэл дахин тооцох зэрээр ажилласан.

эцсийн шатанд хетероскедастиситиг (heteroskedasticity⁶) засварлах үед ашигласан болно.

15. Олон янзын регрессийн шинжилгээнүүдийн R^2 (детерминациийн коэффициент буюу хамаарах хувьсагчид нөлөөлөх үл хамаарах олон хувьсагчийн хамтын нөлөөллөөр тайлбарлагдах хувийг хэмжих хэмжигдэхүүн) нь 0.35-0.55-ийн хооронд өөрчлөгдж байгаа нь ажиглагдаж байсан. Хэдийгээр энэ нь нэлээд доогуур үзүүлэлт мэт боловч түүвэр судалгаанд суурилсан динамик бус регрессийн шинжилгээнд нийтлэг тааралддаг үзүүлэлт бөгөөд эдгээр үр дүнг Монголынхос өөр орнуудын ядуурлын зураглалын ижил үзүүлэлтэй харьцуулан үзэж болох юм. Эдгээр коэффициентууд нь “боломжийн” үр дүнг харуулж байгаа боловч байгуулсан загваруудаа статистикийн үүднээс авч үзвэл цэвэр таамаглалын шинжтэй учир хүн амын аж байдал, ядуурлыг тодорхойлогч биш юм. Суурьшлын шатлал (strata) бүрт хийсэн регрессийн шинжилгээний R^2 харьцангуй бага байгаа явдал нь дөрвөн хүчин зүйлээс шалтгаалж байна. Нэгдүгээрт, олон газруудад өрхүүдийн хэрэглээ харьцангуй ялгаатай байгаа боловч ажиглагдаж байгаа шинж байдлаараа өрхүүд өөр хоорондоо ижил төстэй байна. Энэ нь чухамдаа R^2 бага гараад нөлөөлж байна. Хоёрдугаарт, маш олон тооны боломжит хамаарах хувьсагчууд халттай төгсгөлтэй асуултууд бүхий асуулгатай судалгааны улмаас ажиглагдахгүй орхигдож байна. Гуравдугаарт, олон боломжийн хувьсагчуудын тархалт ижил төстэй биш байгаагаас (дундаж, стандарт алдаа) тооцооны эхний шатанд л хасагдаж байна. Эцэст нь, олон үзүүлэлтүүд хамаарлын чанарыг хангахгүй байна. Ажиглагдаж байгаа олон төрлийн өөр хоорондоо хамарагч хувьсагчдын чанарын их хэмжээний ялгааг анхаараагүйгээс болж боломжит олон хувьсагчийг дэвшүүлсэн таамаглалаа шалгах загвартаа татан оруулах боломжгүй байна.

Үе шат 3: Аж байдлын үзүүлэлтүүд⁷

16. Дээрх үе шатанд хийсэн тооцоонуудыг үндэслэн тооцсон параметрүүдээ⁸ ашиглан Хүн ам, орон сууцны тооллогын тоо мэдээллээр ядуурлын багц үзүүлэлтүүдийг тооцсон. Тухайлбал, ядуурлын хамралтын хүрээ (P_0), ядуурлын гүнзгийрэлтийн индекс (P_1), ядуурлын мэдрэмжийн индекс (P_2). Хоёрдугаар хүснэгтэд ядуурлын тооцооны үзүүлэлтүүдийг суурьшлын шатлал бүрээр нь амьжиргааны түвшний судалгааг үндэслэн тооцсон ядуурлын үзүүлэлтүүдтэй

⁶ Аргачлалын хэсэг болон Нэгдүгээр хавсралтад тайлбарласанчлан Хамгийн бага квадратын загварын доорх таамаглалуудын хоёрыг нь зөрчсөн статистикийн хоёр үндсэн асуудал байгааг илрүүлсэн. Орон зайн автокорреляцыг (нэг бүлэгт байгаа өрхүүдийн зарлага өөр хоорондоо хамааралтай буюу байршилын нөлөөтэй байх) зарим гол хувьсагчуудын Тооллогын нэгжүүдийн дундажийн регрессест оруулах замаар багасгасан. Харин хетероскедастиситиг (ажиглалт бүрт алдааны утга тогтолцоог бүрдсэн ба илуу нарийвчилсан мэдээллийг Элбэр нарын ажил (2002, 2003) болон Мистиайн (2002) нарын ажлаас үзнэ үү.

⁷ Энэхүү ядуурлын зураглалыг гаргахад ашиглалыг ашиглахад зориулсан POMar хэмээх програм хангамж гарсанаар хүн амын аж байдлыг илэрхийлэх үзүүлэлтүүдийг хялбархан тооцдог болсон нь талархууштай. Бид энэ удаад Күйнхүа Жао (2005)-ийн бүтээсэн програм хангамжийн 2005 оны 2 дугаар сарын хувилбарыг ашигласан.

⁸ Өрхийн аж байдлын түвшний регрессийн загвар ашиглан тодорхойлсонос гадна бид хетероскедастисигийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор тусгайлсан загвар байгуулан үнэлсэн. Мөн түүнчлэн бид загварчлах зорилгоор дээрх хоёр төрлийн загварын алдааны утгудын параметрийн тархалтыг үнэлсэн. Илуу нарийвчилсан тайлбарыг аргачлалын талаарх хавсралтаас үзнэ үү.

харьцуулж үзүүлэв. Суурьшлын шатлал бүрт болон ядуурлын үзүүлэлт бүрт Амьжиргааны түвшний судалгааны тоо мэдээллийг ашиглан тооцсон болон хүн амын тооллогын тоо мэдээллийг үндэслэн тооцсон үзүүлэлтүүдийн ижил байдлыг 95 хувийн магадлалтайгаар үгүйсгэх боломжгүй байна⁹.

Хүн амын тооллогын тоо мэдээлэлд суурилан тооцсон ядуурлын хамралтын хүрээ аймгийн төвөөс бусад шатлал бүрт бараг ялгаагүй байгаа бөгөөд зөрүү нь ердөө 2.7 пункт байна. Хэдийгээр тооллогын мэдээлэлд суурилан тооцсон ядуурлын үзүүлэлтүүдийг амьжиргааны түвшний судалгааны мэдээлэлд суурилан тооцсон ядуурлын үзүүлэлтүүдтэй шатлал бүрээр харьцуулж болох боловч эдгээр үзүүлэлтүүдийн адил байдал нь энд ашигласан аргачлалын найдвартай эсэхийг шалгах эвтэй боломжийг олгож байгаа юм.

Хүснэгт 2: Амьжиргааны түвшний судалгааг үндэслэсэн (албан ёсоор зарлагдсан) болон 2000 оны Хүн амын тооллогыг үндэслэсэн (тооцсон) ядуурлын үзүүлэлтүүд, шатлааар

	Ядуурлын хамралтын хүрээ (P_0)		Ядуурлын гүнзгийрэлтийн индекс (P_1)		Ядуурлын мэдрэмжийн индекс (P_2)	
	АТС (Жинхэнэ)	Тооллого (Тооцсон)	АТС (Жинхэнэ)	Тооллого (Тооцсон)	АТС (Жинхэнэ)	Тооллого (Тооцсон)
Улаанбаатар	0.273 (0.026)	0.278 (0.016)	0.081 (0.010)	0.074 (0.006)	0.033 (0.005)	0.029 (0.003)
Аймгийн төв	0.339 (0.022)	0.366 (0.017)	0.105 (0.010)	0.113 (0.008)	0.047 (0.007)	0.050 (0.005)
Сумын төв	0.445 (0.030)	0.439 (0.023)	0.144 (0.015)	0.145 (0.012)	0.064 (0.009)	0.066 (0.007)
Хөдөө	0.427 (0.033)	0.421 (0.024)	0.126 (0.013)	0.128 (0.011)	0.051 (0.007)	0.054 (0.006)

Эх сурвалж: 2002/2003 оны ӨӨЗС/АТС болон 2000 оны Хүн ам, орон сууцны тооллогын тоо мэдээллийг ашиглан зохиогчийн хийсэн тооцоо

Тэмдэглэл: Стандарт алдааны утгуудыг хаалтанд үзүүлэв.

17. Таамаглалаа шалгахад ашигласан янз бүрийн загваруудынхаа найдвартай байдлыг хангасныхаа дараа бид ядуурлын үзүүлэлтүүдийг Нэгдүгээр хүснэгтэд үзүүлсэн бүс, аймаг, сумын түвшинд тооцсон. Гарсан үр дүнг дэлгэн танилцуулахаасаа өмнө бид тооцоолсон үзүүлэлтүүдээ хир нарийвчлалтай болохыг сайтар нягтлан шалгах хэрэгтэй болдог. Дээр аргачлалын хэсэгт дурьдсанчлан, засаг захиргааны нэгжийн буюу суурьшлын янз бүрийн түвшин дэх өрхийн тоо цөөрөх


тусам ядуурлын үзүүлэлтүүдийн нарийвчлал буурч байсан. Аймгийн түвшингийн ядуурлын үзүүлэлтийн нарийвчлал хангалттай сайн эсэхийг нягтлахдаа сумын түвшинд хийсэн тооцоогоо мөн хир нарийвчлалтай болохыг анхааран шалгах нь зүйн хэрэг.

Суурьшлын аль хирийн доод түвшинд бид хүрч чадах вэ?

18. Бид хийсэн тооцооныхоо нарийвчлалд илүү “бодитой” хандах үүднээс засаг захиргааны доод хоёр (аймаг, сум) түвшинд вариацын коэффициентүүдийг тооцоод улмаар тэдгээрийгээ санамсаргүй сонгон авсан болон түгээмэл жишиг болон хэрэглэгддэг коэффициентүүдтэй харьцуулж үзсэн. Доорх Нэгдүгээр зурагт аймаг, сумын түвшин дэх ядуурлын хамралтын хүрээний коэффициентүүдийн тухайд тооцогдсон вариацын коэффициентүүд болон тэдгээрийг (benchmark) 0.2 гэсэн жишиг үзүүлэлттэй харьцуулсан байдлыг үзүүллээ. Нэгдүгээр зураг дахь доод муруй (х -ээр дүрслэгдсэн) бидний тооцсон аймгийн түвшний ядуурлын хамралтын хүрээний нарийвчлал дээд муруйгаар илэрхийлэгдсэн сумын түвшний үзүүлэлтийн нарийвчлалтай харьцуулахад харьцангуй сайн байгааг тодорхой илэрхийлж байна. Сумдын гуравны хоёр орчмынх нь вариацын коэффициент 0.2 гэсэн жишиг үзүүлэлтээс өндөр утгатай байна. Нарийвчлалын энэхүү доод түвшний (вариацын коэффициент өндөр) гол шалтгаан нь тэдгээр сумдын хүн амын тоо цөөн байгаа явдал учир зарим сумуудыг нийлүүлж тооцоонд оруулах замаар асуудлыг шийдвэрлэсэн юм. Ингээд нийт 340 сумдыг 243 болтол тооцооны газар зүйн нэгж болгон нийлүүлж, улмаар тэдгээр нэгжийн тухайд сумын түвшин дэх бүх тооцоог хийсэн болно. Сумуудыг нийлүүлэхдээ хил хязгаар нийлсэн бөгөөд цөөн хүн амтай сумуудыг нэгтгэсэн бөгөөд үр дүнд нь зарим цөөхөн хүн амтай сумуудын ядуурлын үзүүлэлтүүд ижил гарч мэднэ. Гэсэн хэдий ч энэ нь сумын түвшинд нарийвчлал сайтай тооцоо хийх боломжийг олгож байгаа юм. Нэгдүгээр зургаас харахад “нийлүүлсэн сумдын” вариацийн коэффициент нилээд буурсан байгаа боловч заримынх нь өндөр хэвээр байна. Тэгэхлээр тэдгээр нийлүүлсэн сумдын вариацийн коэффициент өндөр хэвээр байх нь асуудал үүсгэх үү? гэдэг асуудал гарна. Хоёрдугаар зураг дээрх “нийлүүлсэн сумдын” вариацийн коэффициентийг ядуурлын хамралтын хүрээний үзүүлэлттэй нь харгалзуулан үзүүллээ. Үүнээс үзэхэд вариацийн коэффициент өндөртэй сумдын дунд ядуурлын хамралтын хүрээ нь (36.0 хувь) үндэсний түвшнийхээс ч өндөр сум байна. Ядуурлын зураглалын гол хэрэглээнүүдийн нэг нь ядуурал ихтэй сум, аймгийг тодорхойлоход оршдог бөгөөд нийлүүлэн авч үзсэн сумдын хувьд ч гэсэн тооцогдсон үзүүлэлтүүдийнх нь нарийвчлал тэдгээрийг зорилтот нэгж болгон сонгоход нийцэхүйц байх ёстой. Ингэж ядуурлын үзүүлэлтийг тооцох нь бодлого боловсруулагчдад чухал удирдамж болж өгнө.


⁹ Тооллогын тоо мэдээллийг ашиглан тооцсон үзүүлэлтүүдийн дунджийн стандарт алдаа нь АТС-ны тоо мэдээллийг ашиглаж тооцсон үзүүлэлтүүдийнхээс системтэйгээр бага байсныг тэмдэглэх нь зүйтэй юм.

Зураг 1: Ядуурлын хамралтын хүрээний үзүүлэлтийн үнэн зөв байдал, засаг захиргааны задласан нэгжээр



19. Ядуурлын үзүүлэлтүүдийг 5 бүс, 21 аймаг, нийслэл хотоор, хот, хөдөөгөөр тооцсоныг Гуравдугаар хүснэгтэд үзүүллээ. Сумын түвшингээр тооцсон үзүүлэлтүүдийг мөн Дөрөвдүгээр хавсралтад үзүүлсэн болно. Стандарт алдааны утгуудыг ч бас дэлгэн харуулсан бөгөөд ихэнх тохиолдолд алдааны хэмжээ тун бага байгаа нь таамаглагдаж буй ядуурлын үзүүлэлтүүд нэлээд бодитой гэдгийг баталж байгаа юм. Энэхүү засаг захиргааны доод түвшингээр задалж мөнгөн дүнгээр хэмжигдсэн ядуурлын үзүүлэлтийг тооцсон нь Монгол Улсын хувьд анхны оролдлого болж байгаа бөгөөд нэгэнт засаг захиргааны нэгжүүдийг газар зүйн байршлаар тодорхойлон авч үзсэн тул тооцооны үр дүнг газрын зураглал хэлбэрээр харуулах нь оновчтой байгаа юм.

Зураг 2: Ядуурлын хамралтын хүрээ ба вариацийн коэффициент, сумын түвшинд



20. Гуравдугаар хүснэгт, Нэгдүгээр хавсралтад үзүүлсэн ядуурлын үзүүлэлтүүдийг бүс, аймаг, sumaар 1-3 дугаар зураглалд тус тус үзүүллээ. 3 дугаар зураглалд үзүүлсэн сумын түвшний тооцоог 4-8 дугаар зураглалд бүс бүсээр нь томсгох замаар үзүүлсэн. Мэдээллийг хүснэгтээр үзүүлэхийн оронд ийнхүү газар зүйн зураглалаар үзүүлснээр хүснэгтээс тэр бүр ажиглагдахгүй газар зүйн байршлаарх мэдээллийг хялбархан харчихаж болдог. Эхний гурван зураглалыг харьцуулснаар ядуурлын үзүүлэлтийг ийнхүү засаг захиргааны нэгж бүрээр задлах нь ядуурлын өвөрмөц дүр төрхийг харах боломжийг олгож байгааг харж болно. Нэгдүгээр зураглалаас баруун бүс нь Монгол Улсын хамгийн ядуурлын түвшин өндөртэй бүс хэмээн харагдаж байгаа бөгөөд үлдсэн хэсэгт нь ядуурлын түвшин харьцангуй бага, мөнгөн дүнгээр хэмжигдсэн ядуурлын түвшин нь өөр хоорондоо ойролцоо байна. Цаашилбал, амьжиргааны түвшний судалгааны тоо мэдээллийг ашиглан ийм тооцоог засаг захиргааны буюу суурышлын хамгийн боломжит доод түвшинд хүртэл хийх боломжтой. Харин Хоёрдугаар зураглалаас бүсийн түвшинд ядуурлын түвшин адил биш байгааг ажиглаж болно. Тухайлбал, Баруун бүст гэхэд Ховд аймагт ядуурлын түвшин бусад аймгаас илүү өндөр байгаа бөгөөд харин бусад аймгуудынх нь ядуурлын түвшин Төвийн бүсийн аймгуудынхтай адил төстэй байна. Үүний нэгэн адил Зүүн бүсийн аймгуудаас Дорнод аймагт ядуурлын түвшин нэлээд өндөр байгаа бөгөөд бусад аймгуудынх нь харин үндэсний дунджаас доогуур буюу ядуурлын түвшин бага байна. Харин

3-8 дугаар зураглалуудаас хараад аймгуудын доторх сумуудын ядуурлын түвшин өөр хоорондоо тун ижил төстэй байна. Зарим тохиолдолд (Өмнөговь, Дорнод, Баянхонгор аймгуудад) бүх сумдынх нь ядуурлын үзүүлэлтүүд тус тусынхаа аймгийн ядуурлын үзүүлэлтийн түвшинд байна. Ихэнх тохиолдолд тодорхой аймгийн хувьд маш цөөхөн сумдынх нь ядуурлын үзүүлэлтүүд тухайн аймгийнхаа ядуурлын үзүүлэлтээс эрс дээш эсвэл эрс доош байна.

Суурьшлын аль хир доод түвшинд хүрэх ёстой вэ?

21. Аймаг, сумдын тооцоолсон ядуурлын үзүүлэлтийг хир итгэлтэй ашиглаж болохыг дээр бид үзүүллээ. Гэхдээ ингэж нарийвчлан тооцсон үзүүлэлтүүд илүү их мэдээлэл өгөхгүй тохиолдол ч гарч мэдэх юм. Магадгүй дотооддоо ижил төстэй, онц ялгаагүй аймгуудын сумд нь өөр хоорондоо мөнгөн дүнгээр хэмжигдсэн ядуурлын түвшингээрээ статистикийн хувьд ижил төстэй байж болох юм. Гэхдээ бид тооцооллоо аймгаас сум руу задлах тусам хир хэмжээний илүү мэдээлэлтэй болж байгааг шалгаж үзэхийн тулд тухайн сумын түвшинд тооцсон ядуурлын үзүүлэлтүүдээ тус тусынх нь аймгийн үзүүлэлттэй, улсын дүнгийн үзүүлэлттэй харьцуулан авч үзсэн. Ингэхэд 340-сумаас 59-ийнх нь ядуурлын түвшин улсын дунджаас дээгүүр, 21 сумынх нь улсын дунджаас доогуур буюу ядуурал багатай байна. Сумдыг тус тусынх нь аймгийн түвшинтэй харьцуулж үзэхэд 76 сум илүү ядуу, 60 сум нь ядуурал багатай байна. Энэхүү дүр зураг ядуурлын гүнзгийрэлт, мэдрэмжийн үзүүлэлтийн тухайд ч төстэй байна. Энэ нь ядуурлын үзүүлэлтийг аймгийн түвшинд тооцсоноос сумын түвшинд тооцох нь ядуурлыг бууруулах зорилтот арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд илүү чухал ач холбогдолтой гэдгийг илэрхийлж байна. Бидний танилцуулж буй эдгээр үр дүн нь ядуурлын зураглалыг зөвхөн аймаг, сумын түвшинд гаргахын ач холбогдол, төлөв байдлыг илэрхийлж байгаа юм. Харин цаашид илүү сайн зорилтот үзүүлэлтүүдийг бий болгох, илүү гүнзгий судалгаа шинжилгээ хийх шаардлагатай.

Хүснэгт 3: Ядуурлын үзүүлэлтүүд, бүс, аймагар

Тооллогын код	Засаг, захиргааны нэгж: Бүс, аймаг	Хүн ам	Ядуурлын хамраалтын хүрээ (P0)	Хөдөө		Хүн ам	Хамраалтын хүрээ (P0)	Ядуурлын гүнзгийрэлтийн индекс (P1)	Хамраалтын хүрээ (P0)	Ядуурлын гүнзгийрэлтийн индекс (P1)
				Хот	Бүгд					
10000	БАРУУН	112,629	0.362 (0.019)	0.109 (0.009)	310,797 (0.030)	0.500 (0.015)	0.163 (0.015)	423,426 (0.027)	0.463 (0.014)	0.149 (0.014)
10200	Баян-Өлгий	26,146	0.365 (0.024)	0.109 (0.011)	65,456 (0.049)	0.462 (0.022)	0.142 (0.016)	91,602 (0.039)	0.434 (0.042)	0.132 (0.019)
10500	Говь-Алтай	15,905	0.161 (0.056)	0.040 (0.017)	48,236 (0.034)	0.472 (0.016)	0.146 (0.016)	64,141 (0.039)	0.395 (0.016)	0.120 (0.016)
10900	Завхан	18,548	0.389 (0.025)	0.118 (0.011)	72,234 (0.034)	0.448 (0.015)	0.137 (0.015)	90,782 (0.032)	0.436 (0.015)	0.133 (0.015)
11500	Үвс	26,421	0.421 (0.025)	0.131 (0.012)	63,735 (0.047)	0.486 (0.023)	0.156 (0.023)	90,156 (0.041)	0.467 (0.020)	0.149 (0.020)
11600	Ховд	25,609	0.401 (0.025)	0.124 (0.011)	61,136 (0.055)	0.638 (0.037)	0.239 (0.037)	86,745 (0.046)	0.568 (0.029)	0.205 (0.029)
20000	ХАНГАЙ	174,706	0.373 (0.023)	0.117 (0.011)	378,209 (0.028)	0.407 (0.013)	0.125 (0.013)	552,915 (0.026)	0.396 (0.012)	0.122 (0.012)
20100	Архангай	18,870	0.342 (0.024)	0.101 (0.010)	79,204 (0.033)	0.441 (0.014)	0.133 (0.014)	98,074 (0.031)	0.422 (0.014)	0.126 (0.014)
20300	Баянхонгор	22,532	0.409 (0.028)	0.128 (0.013)	63,082 (0.035)	0.492 (0.017)	0.155 (0.017)	85,614 (0.033)	0.470 (0.016)	0.148 (0.016)
20400	Булган	12,953	0.329 (0.026)	0.096 (0.010)	49,944 (0.047)	0.238 (0.015)	0.067 (0.015)	62,897 (0.043)	0.257 (0.014)	0.073 (0.014)
21000	Өвөрхангай	19,621	0.155 (0.052)	0.037 (0.015)	92,327 (0.049)	0.316 (0.015)	0.089 (0.017)	111,948 (0.050)	0.288 (0.017)	0.080 (0.017)
21700	Хөвсгөл	29,780	0.392 (0.023)	0.121 (0.010)	90,347 (0.048)	0.502 (0.025)	0.166 (0.015)	120,127 (0.042)	0.475 (0.021)	0.155 (0.021)
22100	Орхон	70,950	0.430 (0.043)	0.141 (0.026)	3,305 (0.067)	0.408 (0.029)	0.128 (0.029)	74,255 (0.044)	0.429 (0.021)	0.140 (0.021)


	ТӨВ	160,479	0.327 (0.019)	0.097 (0.008)	285,134 (0.026)	0.421 (0.012)	0.134 (0.017)	445,613 (0.024)	0.387 (0.011)	0.121 (0.014)
30600	Дорнговь	18,175	0.323 (0.022)	0.096 (0.009)	32,905 (0.039)	0.393 (0.017)	0.122 (0.013)	51,080 (0.033)	0.368 (0.013)	0.113 (0.014)
30800	Дундговь	14,574	0.385 (0.027)	0.118 (0.012)	37,241 (0.040)	0.438 (0.018)	0.133 (0.018)	51,815 (0.037)	0.423 (0.017)	0.129 (0.016)
31100	Өмнөговь	14,097	0.365 (0.025)	0.113 (0.011)	31,684 (0.057)	0.265 (0.018)	0.073 (0.018)	45,781 (0.047)	0.296 (0.016)	0.085 (0.016)
31300	Сэлэнгэ	22,740	0.346 (0.029)	0.105 (0.013)	78,003 (0.034)	0.480 (0.024)	0.162 (0.017)	100,743 (0.033)	0.450 (0.016)	0.149 (0.016)
31400	ТӨВ	14,711	0.338 (0.025)	0.102 (0.011)	83,992 (0.030)	0.426 (0.014)	0.131 (0.014)	98,703 (0.029)	0.413 (0.013)	0.127 (0.013)
31900	Дархан-Уул	67,119	0.296 (0.021)	0.085 (0.008)	17,923 (0.041)	0.414 (0.018)	0.136 (0.018)	85,042 (0.025)	0.321 (0.010)	0.096 (0.016)
32200	Говьсумбэр	9,063	0.348 (0.028)	0.105 (0.012)	3,386 (0.011)	0.545 (0.075)	0.216 (0.051)	12,449 (0.051)	0.402 (0.029)	0.136 (0.029)
40000	ЗҮҮН	74,421	0.440 (0.031)	0.146 (0.016)	130,974 (0.039)	0.336 (0.015)	0.100 (0.015)	205,395 (0.036)	0.374 (0.015)	0.117 (0.015)
40700	Дорнод	40,548	0.476 (0.048)	0.165 (0.024)	35,996 (0.037)	0.486 (0.018)	0.159 (0.018)	76,544 (0.043)	0.481 (0.021)	0.162 (0.021)
41200	Сүхбаатар	15,576	0.383 (0.025)	0.117 (0.011)	41,063 (0.063)	0.272 (0.021)	0.074 (0.021)	56,639 (0.053)	0.303 (0.018)	0.086 (0.018)
41800	Хэнтий	18,297	0.407 (0.025)	0.128 (0.012)	53,915 (0.051)	0.285 (0.018)	0.081 (0.018)	72,212 (0.044)	0.316 (0.016)	0.093 (0.016)
50000	Улаанбаатар	772,969	0.278 (0.016)	0.074 (0.006)	772,969 (0.016)	0.278 (0.006)	0.074 (0.006)
52000	Улаанбаатар	772,969	0.278 (0.016)	0.074 (0.006)	772,969 (0.016)	0.278 (0.006)	0.074 (0.006)

Эх сурвалж: 2002/2003 оны ӨӨЗС/АТС болон 2000 оны Хүн ам, орон сууцны тооллогын тоо мэдээллийг ашиглан зохиогчийн хийсэн тооцоо

Тэмдэлэл 1: Стандарт алдааны ултуудыг хайлтэнд үзүүлэв.


Тэмдэлэл 2: Бусудийн тод угсрээр тэмдэлэж, аймгуудыг харгалзах бүсд нь харгалзуулан жагсаав.

Зураглал 1: Ядуурлын хамралтын хүрээ, бүсээр




Эх сурвалж: 2002/2003 оны ӨӨЗС/АТС болон 2000 оны Хүн ам, орон сууцны тооллогын тоо мэдээллийг ашиглан зохиогчийн хийсэн тооцоо

Зураглал 2: Ядуурлын хамралтын хүрээ, аймгаар




Эх сурвалж: 2002/2003 оны ӨӨЗС/АТС болон 2000 оны Хүн ам, орон сууцны тооллогын тоо мэдээллийг ашиглан зохиогчийн хийсэн тооцоо

Зураглал 3: Ядуурлын хамралтын хүрээ, сумаар




Эх сурвалж: 2002/2003 оны ФОЗС/АТС болон 2000 оны Хүн ам, орон сууцны тооллогын тоо мэдээллийг ашиглан зохиогчийн хийсэн тооцоо

Зураглал 4: Ядуурлын хамралтын хүрээ, Баруун бүс, Сумаар




Эх сурвалж: 2002/2003 оны ФОЗС/АТС болон 2000 оны Хүн ам, орон сууцны тооллогын тоо мэдээллийг ашиглан зохиогчийн хийсэн тооцоо

Зураглал 5: Ядуурлын хамралтын хүрээ, Хангайн бүс, Сумаар




Эх сурвалж: 2002/2003 оны ФОЗС/АТС болон 2000 оны Хүн ам, орон сууцны тооллогын тоо мэдээллийг ашиглан зохиогчийн хийсэн тооцоо

Зураглал 6: Ядуурлын хамралтын хүрээ, Төвийн бүс, Сумаар




Эх сурвалж: 2002/2003 оны ФОЗС/АТС болон 2000 оны Хүн ам, орон сууцны тооллогын тоо мэдээллийг ашиглан зохиогчийн хийсэн тооцоо

Зураглал 7: Ядуурлын хамралтын хүрээ, Улаанбаатар хот, Дүүргээр




Эх сурвалж: 2002/2003 оны ФОЗС/АТС болон 2000 оны Хүн ам, орон сууцны тооллогын тоо мэдээллийг ашиглан зохиогчийн хийсэн тооцоо

Зураглал 8: Ядуурлын хамралтын хүрээ, Зүүн бүс, Сумаар



Эх сурвалж: 2002/2003 оны ФОЗС/АТС болон 2000 оны Хүн ам, орон сууцны тооллогын тоо мэдээллийг ашиглан зохиогчийн хийсэн тооцоо

Зураглал 9: Ядуурлын хамралтын хүрээ дэх хүйсийн ялгаа, аймгаар



Эх сурвалж: 2002/2003 оны ФОЗС/АТС болон 2000 оны Хүн ам, орон сууцны тооллогын тоо мэдээллийг ашиглан зохиогчийн хийсэн тооцоо

ЖЕНДЭР

22. Хэдийгээр бидний ашиглаж байгаа аргачлал байршилыг үндэслэсэн мэдээллийг тооцоход голчлон хэрэглэгддэг ч ядуурлын үзүүлэлтүүдийг ихээхэн хүн амтай хүн амын тодорхой бүлгүүдээр тооцоход ашиглаж болно. Монгол Улсын хувьд нийт өрхийн 16 орчим хувийг эмэгтэйчүүд тэргүүлж байна. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн аль алинаар толгойлуулсан өрхүүдийн ядуурлын түвшин дунджаар 37 хувь байгаа бөгөөд эмэгтэйчүүдийн тэргүүлсэн өрхүүдийн ядуурлын байдал тийм ч муу биш байна. Гэхдээ, 9 дүгээр зураглаас үзэхэд зарим аймгуудад жендэрийн бага зэргийн ялгаа ажиглагдаж байгаа боловч зарим аймагт бүр “урвуу” байдал ч ажиглагдаж байна. Дүгнэж хэлэхэд, тэдгээр жендэрийн ялгаатай байдлын аль нь ч 95 хувийн итгэмжлэгдсэн завсарт тэгээс онцгой ялгаатай биш байна.

ДҮГНЭЛТ

23. Монгол Улсын хүн амын ядуурлын үзүүлэлтийг бүс, аймаг, sumaар хэрхэн ядуурлын зураглал хэлбэртэй гаргасныг энэхүү тайландаа үзүүллээ. Элбэр болон түүний хамтрагчдын боловсруулсан (2003) энэхүү аргачлалыг ашиглан Монгол Улсын засаг захиргааны буюу суурышлын боломжит доод түвшин хүртэлх түвшинд ядуурлын үзүүлэлтийг анх удаа тооцлоо. Ингэж засаг захиргааны түвшинд задлан тооцсон үзүүлэлтүүд нь Монгол Улсад албан ёсоор зарлагдсан тухайн үеийн тоо мэдээлэлтэй нийцэж байна.

24. Тооцоонд ашигласан аргачлалын давуу тал нь тухайн тооцоолсон ядуурлын янз бүрийн үзүүлэлтүүдийн стандарт алдааг тооцох боломж олгодог учир үр дүнгийн үнэн зөвийн талаар итгэлтэй байх бололцоотой. Бид энд дэлгэн үзүүлсэн үр дүнгийн үзүүлэлтүүд төлөвлөлт, бодлого боловсруулагчид, судлаачид ашиглаж болохуйцаар хангалттай сайн нарийвчлагдсан гэж дүгнэж байна.

25. Хамгийн гол нь эдгээр тооцооны үзүүлэлтийг ашиглах явдал чухал бөгөөд хэрхэн ашигласнаар түүний ач холбогдолыг нь илэрхийлэх болно. Харин яаж хэрэглэх вэ? Юуны өмнө эдгээр тооцоог төвөөс бүс нутгуудад, бүс нутгуудаас аймаг, суманд гэх мэтээр дээрээс доод нэгжид төсвийг засаг захиргааны янз бүрийн түвшинд оновчтой байршуулах төлөвлөгөө гаргахад ашиглах нь чухал. Эдгээр зураглал нь Монгол Улсад хийж байгаа төвлөрөлийг сааруулах үйл явцад дэмжлэг үзүүлэх чухал хэрэгсэл болж мэдэх юм. Ядуурлын үйл явц бол маш олон хүчин зүйл, үйл явцаас хамаарч байдаг учир энэхүү мөнгөн дүнгээр хэмжигдсэн ядуурлын үзүүлэлтүүд дээр нэмэлт болгож боловсрол, эрүүл мэнд, дэд бүцийн гэх мэт бусад олон хэмжигдэхүүнүүдийг тооцох шаардлагатай. Иймд МХЗ-ын үзүүлэлтүүдээр мөн хэд хэдэн цуврал зураглал гаргаж байгаа болно. Ядуурлын зураглалыг боловсрол, эрүүл мэндийн зураглалтай хавсруулан гаргах нь тодорхой бүлэгт чиглэсэн үйл ажиллагаа явуулах маш хүчирхэг хэрэгсэл болох юм. Мөн түүнчлэн ядуурлын зураглалыг орон нутагт хэрэгжүүлж байгаа ядуурлыг бууруулах янз бүрийн арга хэмжээг (нийгмийн халамжийн сан, хот/сум хөгжүүлэх хөтөлбөр гэх мэт) үнэлэх, нөлөөллийн судалгаа шинжилгээ хийх зэрэгт ашиглаж болно. Эцэст нь судлаачид ядуурлын тархалтыг нийгэм, эдийн засгийн олон үр дүн, үйл явцтай холбон судлахад ашиглах боломжтой.

REFERENCES

- Coulombe, H. And Q. Wodon, 2007, Combining census and household survey data for better targeting: The West and Central Africa Poverty Mapping Initiative, Findings Africa Region No. 280, The World Bank, Washington, D.C.
- Elbers, Chris, Jean Olson Lanjouw, and Peter Lanjouw, 2002, “Welfare in Villages and Towns: Micro level Estimation of Poverty and Inequality.” Policy Research Working Paper No. 2911, DEC RG-World Bank, Washington DC
- Elbers, Chris, Jean Olson Lanjouw, and Peter Lanjouw, 2003, “Micro-Level Estimation of Poverty and Inequality” Econometrica, 71(1), 355-364
- Henninger, Norbert, 1998, Mapping and Geographical Analysis of Human Welfare and Poverty, Review and Assessment, World Resources Institute, Washington, D.C.
- National Statistical Office (CSO), 2004, Main Report of “Household Income and Expenditure Survey / Living Standards Measurement Survey”, 2002-2003, Ulaanbataar: National Statistical Service
- Mistiaen, Johan, Berk Ozler, Tiaray Razafimanantena and Jean Razafindravonona, 2002, Putting Welfare on the Map in Madagascar, Africa Region Working Paper Series, Number 34, The World Bank. Washington, D.C.
- Zhao, Qinghua, 2005, User Manual for PovMap, mimeo, Development research Group, The World Bank, Washington, D.C.

ХАВСРАЛТ 1: Аргачлал

Элбэрс, Ланжоу болон Ланжоу (2002, 2003) нарын зохиосон аргачлалын үндсэн санаа тун энгийн. Эхлээд амьжиргааны түвшний судалгаа болон хүн амын тооллогын альалинд нь байгаа ижил үзүүлэлтээс сонгон аваад амьжиргааны түвшний судалгааны мэдээн дээр үндэслэн нэг хүнд ногдох зардлын логарифмчлагдсан утгуудын тухайд регрессийн загвар байгуулан үнэлнэ. Дараа нь регрессийн параметрүүдийг ашиглан тооллогод хамрагдсан өрхийн зардлыг таамаглах оролдлого хийнэ. Үүний дараа хүн амын аж байдлын хэд хэдэн үзүүлэлтүүдийг газар зүйн байршлын дэд бүлгүүдээр тооцон гаргана.

“Хүн амын аж байдлын” гэж нэрлэж буй энэ үзүүлэлтэд өрхийн зарлага дээр үндэслэсэн багц үзүүлэлтүүдийг багтаасан. Ядуурлын хамралтын хүрээг (P^0) авч үзсэн бөгөөд үүнээс гадна ядуурал болон орлогын тэгш бус байдлын бусад үзүүлэлтүүдийг тооцон гаргах боломжтой. (Аткинсоны тэгш бус байдлын хэмжүүр, ерөнхийлсөн Энтропи бүлгийн тэгш бус байдлын индекс, FGT ядуурлын хэмжүүр болон Жини коэффициент).

Энэ арга нь харьцангуй энгийн арга мэт боловч үүнийг зөв зүйтэй хэрэглэх явдал нь регрессийн загварт орон зайн автосорреляци болон хетероскедастисити гэх мэт асуудал байгаа эсэхийг нягтлан засварлах үед нэлээд нарийвчилсан цогц тооцооллыг шаардана. Мөн түүнчлэн, аж байдлын олон үзүүлэлтийг эдгээрийн стандарт алдааны хамт тооцох шаардлага гардаг бөгөөд энэ нь уг тооцооллыг хийх явдлыг нэлээд амар бус болгодог.

Ядуурлын зураглал хийх аргачлалыг доорхи гурван үе шатаар тайлбарласан бөгөөд үе шат бүр нь энэ зураглал хийхэд чухал алхамууд болно. Эдгээрийг дээр дурьдсан Элбэрс, Ланжоу болон Ланжоу (2002, 2003); мөн Мистаен (2002) нарын онолын материалуудаас иш татлаа.

Эхний үе шат

Юуны өмнө амьжиргааны түвшний судалгаа болон тооллогоос тодорхой ижил шалгуурыг хангасан “тайлбарлагч үзүүлэлтүүд”-ийг тодорхойлно. Бидний байгуулж буй ядуурлын зураглалыг ядуурлын үзүүлэлтүүдтэй нийтгэй байлгахын тулд тооллого болон амьжиргааны түвшний судалгааны аль алинаас нь авсан, харьцуулж болохуйц үзүүлэлтүүдийг сонгож авах нь чухал. Ингэхдээ эхлээд эдгээр тооллого, судалгаанд хэрэглэсэн асуултууд болон тэдгээрт өгсөн хариулт тус бүрийг шалгана. Сонгосон асуултуудаа ашиглан багц үзүүлэлтүүдийг гарган авна. Хэдийгээр бид үзүүлэлт тус бүрийн тархалт ижил эсэхийг харьцуулж болох боловч практикт зөвхөн тэдгээрийн дундаж утга ижил эсэхийг нягтлах замаар хязгаарладаг. Дараагийн үе шатанд байгуулах загваруудынхаа таамаглах чадварыг нэмэгдүүлэх үүднээс эдгээр тооцоолол, дүн шинжилгээнүүдийг шатлал (strata) тус бүрээр хийнэ.

Боломжит бүх үзүүлэлтүүдийн жагсаалт болон эдгээрийн дундаж ижил эсэхийг шалгасан шинжүүрийн үр дүнг Хавсралт 2-т үзүүлэв.

Хоёр дахь үе шат

Эхлээд амьжиргааны түвшний судалгааны мэдээллийн баазыг ашиглан нэг хүнд ногдох өрхийн зардлыг загварчилсан. Тооцооллын нарийвчлалыг хангахын тулд газар зүйн байршлын хамгийн бага шатлалын хувьд загвараа үнэлсэн. ATC-ны хувьд тэрхүү шатлал нь түүврийн суурышлын шатлал болох: Улаанбаатар хот, аймгийн төвүүд, сумын төвүүд болон хөдөө юм.

Газар зүйн байршлын хувьд С-д орших h өрхийн зардлын түвшин (y_{ch})-гийн загварыг байгуульяа. x_{ch} нь тайлбарлагч хүчин зүйлсийн багц бөгөөд, харин u_{ch} нь үлдэгдэл хүчин зүйлийг илэрхийлнэ:

$$\ln y_{ch} = E[\ln y_{ch} | \mathbf{x}_{ch}] + u_{ch} \quad (1)$$

Байршил нь эхний үе шатанд тодорхойлсоноор түүврийн бүлгийг илэрхийлнэ. Энэ нь олонх тохиолдолд тооллогын нэгжийг илэрхийлдэг боловч заавал ийм байх албагүй. “Тайлбарлагч хүчин зүйлс” нь тооллого болон амьжиргааны түвшний судалгааны асуулгын аль алинд ижил орших ёстой бөгөөд адил хэлбэртэй тодорхойлогдсон байх ёстой. Мөн түүнчлэн эдгээр хүчин зүйлс нь хүн амын аж байдлын янз бүрийн үзүүлэлтийг бодитой хэмжин харуулахын тулд ойролцоо цаг хугацааны мэдээллийг агуулсан байх шаардлагатай. Бүх боломжит хүчин зүйлсийн жагсаалтыг эхний үе шатад тодорхойлсон.

Хэрвээ дээрх тэгшитгэлийг шугаман тэгшитгэл болгоё гэвэл нэг өрхөд ногдох зардлын тэгшитгэлийг дараах байдлаар логарифмчилна.

$$\ln y_{ch} = \mathbf{x}_{ch}' \boldsymbol{\beta} + u_{ch} \quad (2)$$

Алдаа/үлдэгдэл хүчин зүйлсийн утгуудын вектор \boldsymbol{u} нь $F(0, \Sigma)$ тархалттай байх ба энэхүү шугаман тэгшитгэл (2)-ийг Ерөнхийлсөн хамгийн бага квадратын аргаар (GLS) үнэлнэ. Үүнийгүнэлэхдээ боломжитавто корреляци болон хетеросидастисити (ижил нэгжээс сонгогдсон өрхүүдийн зардал нь харилцан хамааралтай байх) – ийн асуудлуудыг тооцоонд харгалзан үзэхийн тулд эн тэргүүнд алдааны вариац, ковариацын матриц Σ -уудыг үнэлэх хэрэгтэй болно. Ингэхдээ эхлээд алдааны утгаа дараах байдлаар тодорхойлно:

$$u_{ch} = \eta_c + \varepsilon_{ch} \quad (3)$$

η_c -нь байршлын нөлөөг, харин ε_{ch} -нь алдааны утгуудыг тус тус илэрхийлнэ.

¹⁰ Аргачлалын талаарх буюу загварчлалын онолын илүү нарийвчилсан мэдээллийг Mistiaen et al. (2002)-с үзнэ үү.

Бодит байдалд тэгшитгэл (2)-ийг энгийн Хамгийн бага квадратын аргаар үнэлэх бөгөөд алдааны хэлбэлзэлийг үлдэгдэл хүчин зүйлсийг ашиглан үнэлж $\hat{\mu}_{ch}$ -аар илэрхийлнэ. Ингээд өөр хоорондоо хамааралгүй өрх болон байршлын бүрэлдэхүүнүүдийн дундаж үлдэгдэл хүчин зүйлсийн утгыг дараах байдлаар задлана:

$$\hat{u}_{ch} = \hat{\eta}_c + e_{ch} \quad (4)$$

Байршлын хүчин зүйлийг ($\hat{\eta}_c$) нийт үлдэгдлийн (residuals) дунджаар үнэлэх тул өрхийн бүрэлдэхүүн (e_{ch})-ийг хасч тооцно. Ингээд (e_{ch}^2)-ийг загвар 2 дахь бүх үл хамаарах хүчин зүйлээр регрессчлэх замаар хетеросидастиситиг загварчилна. Энд ложистик загварыг ашигласан¹⁰.

Алдааны энэ хоёр тооцоог дараах хоёр матрицыг гаргахад ашигласан. Үүнд: $\hat{\Sigma}$ ба анхны загвар 2-ын үнэлэгдсэн вариац, ковариацын матриц болно. Сүүлийн матриц нь загвар 2-ын коэффицентүүдийг үнэлэх боломжийг өгнө.

Гуравдугаар үе шат

Ядуурлын зураглалыг гүйцээхийн тулд бид нэг өрхөд ногдох зардлын хэмжээг болон үүнд ногдож буй алдааг тооцож гаргахын тулд хоёрдугаар үе шатад тооцогдсон параметрүүдийг тооллогын өрх тус бүрээр гаргаж ирнэ.

Аж байдлын индексүүдийн вариацын тооцоо нь маш нарийн төвөгтэй үйлдэл учир аж байдлын индексийн дисперсийг тооцохдоо bootstrapping аргыг хэрэглэсэн. Өмнөх үе шатаар холбогдох үзүүлэлтүүдийн хэд хэдэн коэффициентүүд болон алдааны утгуудыг гарган авсан. Ингээд тооллогын бүх өрхөөр таамаглагдаж буй утга болон алдааны утга дээр үндэслэн өрхийн аж байдлын индексийг (\hat{y}_{ch}^r) дараах байдлаар тооцон гаргасан:

$$\hat{y}_{ch}^r = \exp(\mathbf{x}_{ch}' \tilde{\beta}^r + \tilde{\eta}_c^r + \tilde{\varepsilon}_{ch}^r) \quad (5)$$

Энэ тооцоог хэдэн 100 дахин давтан хийх бөгөөд ингэх бүрдээ бүх коэффициентүүд болон харгалзах алдааны утга бүрийг тооцно. Тооцон гаргасан өрхийн аж байдлын индекс нь бидний гол үзүүлэлт бөгөөд энэ индексийн стандарт хазайлт нь энэ тооцооны стандарт алдааг илэрхийлнэ.

ХАВСРАЛТ 2А: Тооцооны/үр дүнгийн (predictors) үзүүлэлтүүдийн тайлбар

hhszie	Household size
kid06	Number of children aged between 0 and 6
boy714	Number of boys aged between 7 and 14
girl714	Number of girls aged between 7 and 14
male	Number of adult males between 15 and 64
female	Number of adult females between 15 and 64
elderly	Number of elderly aged 65 or more
hd_male	=1 if household head is a male; 0 if not
hd_literate	=1 if household head is literate; 0 if not
hd_noneduc	=1 if household head has no formal education; 0 if not
hd_primary	=1 if household head went to primary school (at most); 0 if not
hd_secondary	=1 if household head went to secondary school (at most); 0 if not
hd_tertiary	=1 if household head went to post secondary school; 0 if not
hd_single	=1 if household head is single; 0 if not
hd_couple	=1 if household head is in couple; 0 if not
hd_primesec	=1 if household head works in the primary sector; 0 if not
hd_secesec	=1 if household head works in the secondary sector; 0 if not
hd_teresec	=1 if household head works in the tertiary sector; 0 if not
hd_occupied	=1 if household head works; 0 if not
hd_empl	=1 if household head works as an employee; 0 if not
hd_selfempl	=1 if household head is self-employed; 0 if not
hd_age	Age of household head (in years)
no_spouse	=1 if there is no spouse in the household; 0 if not
sp_literate	=1 if spouse is literate; 0 if not
sp_noneduc	=1 if spouse has no formal education; 0 if not
sp_primary	=1 if spouse went to primary school (at most); 0 if not
sp_secondary	=1 if spouse went to secondary school (at most); 0 if not
sp_tertiary	=1 if spouse went to post secondary school; 0 if not
sp_primesec	=1 if spouse works in the primary sector; 0 if not
sp_secesec	=1 if spouse works in the secondary sector; 0 if not
sp_teresec	=1 if spouse works in the tertiary sector; 0 if not
sp_occupied	=1 if spouse works; 0 if not
sp_empl	=1 if spouse works as an employee; 0 if not
sp_selfempl	=1 if spouse is self-employed; 0 if not
sp_age	Age of spouse (in years)
pooc	Proportion of household members being occupied
psch	Proportion of household members currently going to school
type_house	=1 if household lives in a house; 0 if not
type_apart	=1 if household lives in an apartment; 0 if not
type_ger	=1 if household lives in an ger; 0 if not
type_other	=1 if household lives in another type of building; 0 if not
prop_private	=1 if household owns its dwelling; 0 if not
sqm	Dwelling floor area in squared meters for all types of dwelling
sqm2	Sqm squared
sqm_ger	Dwelling floor area in squared meters for ger only; 0 if not
sqm2_ger	Sqm_ger squared
water_pipe	=1 if household uses pipe as their main source water; 0 if not
water_well	=1 if household uses well as their main sources of water; 0 if not

